



## **“ЕВРОП СУДЛАЛ: ХЭЛ ШИНЖЛЭЛ, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, ОРОН СУДЛАЛ-VI” ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ**

“Европ судлал: хэл шинжлэл, олон улсын харилцаа, орон судлал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний VI хурлыг МУИС-ийн Шинжлэх Ухааны сургуулийн Европ судлалын тэнхим, ШУТИС-ийн Гадаад хэлний сургууль, МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль, ШУА-ийн ОУХ-ны хүрээлэн, Хүмүүнлэгийн ухааны их сургууль хамтран **2022 оны 04 дүгээр сарын 08**-ны баасан гарагт цахимаар зохион байгуулна.

Тус хурал нь Монгол Улс болон гадаад орнуудын их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, Европын түгээмэл хэл (англи, франц, герман, итали, испани, орос, польш, чех)-ний сургалт, хэл шинжлэл, олон улсын харилцаа, орон судлал, орчуулгын судалгааг гүнзгийрүүлж багш, судлаачдын чадавхыг хөгжүүлэх, хамтран мэдлэг бүтээх, түгээх ач холбогдолтой үйл ажиллагаа юм.

### **Хурлын зорилго:**

Монгол Улсад Баруун болон Төв, зүүн Европын улс орнуудын хэл, уран зохиол, түүх, соёл, боловсрол, нийгэм эдийн засаг, олон улсын харилцаа, улс төр судлалыг хөгжүүлэх, их дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын багш, судлаачдын мэдлэгийг түгээх, тэдний чадавхыг нэмэгдүүлэх, Европ судлалыг олон улсын харилцаа, орон судлал, хэл шинжлэл ба орчуулга зүй, гадаад хэлний боловсролын орчин үеийн сургалт, судалгааны чиг хандлагад ойртуулах, туршлага, мэдээлэл солилцох, цаашид хамтарсан судалгааны төсөл, хөтөлбөр боловсруулах санаачилга боломжийг хэлэлцэх зорилготой.

### **Хурлын хамрах хүрээ:**

Дотоод, гадаадын их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллага, мэргэжлийн холбоо оролцох боломжтой.

### **Салбар хуралдаан:**

- Олон улсын харилцаа, орон судлал
- Хэл шинжлэл, орчуулга зүй
- Гадаад хэлний боловсрол

*Хуралд оролцох хүсэлтээ багш судлаач, докторантууд товч танилцуулгын хамт хурал зохион байгуулах ажлын хэсгийн [europeanstudies.num@gmail.com](mailto:europeanstudies.num@gmail.com) цахим хаягаар **2022 оны 2-р сарын 28-ны дотор** ирүүлнэ. Хурлын албан ёсны хэл нь монгол хэл бөгөөд англи, орос хэлээр илтгэх боломжтой.*

Товч танилцуулга	Монголоор	Англиар	
Овог, нэр	√	√	
Улс, хот	√	√	
Байгууллага	√	√	
Албан тушаал	√	√	
Эрдмийн зэрэг, цол	√	-	
Холбоо барих утас	√	-	
Цахим шуудан	√	-	
Илтгэл хэлэлцүүлэх салбар хуралдаан	√	√	
Илтгэлийн нэр	√	√	

### Илтгэлд тавигдах ерөнхий шаардлага:

Илтгэл нь сэдэв, агуулгын хувьд:

- ✓ **Олон улс харилцаа, орон судлал:** Монгол Улс болон Европын орнуудын хамтын ажиллагаа, олон улсын харилцаа, бүс нутаг судлал, Европын орнуудын түүх, нийгэм, улс төр, соёл судлал, соёл хоорондын харилцаа
- ✓ **Хэл шинжлэл, орчуулга зүй:** орчин цагийн хэл шинжлэлийн онол, арга зүй, салбарын болон салбар дундын судалгаа, орчуулгын онол, зарчим, арга, төрөл, орчуулгын шүүмж, утга зохиол судлал
- ✓ **Гадаад хэл эзэмших:** гадаад хэл эзэмших онол, аргазүйн асуудал чиглэлд салбарын судалгааны онол, арга зүйн хувьд шинэлэг санаа дэвшүүлсэн байх
- ✓ Илтгэлийн PPT бэлдсэн байх

### Илтгэлд тавигдах техникийн шаардлага:

- ✓ Илтгэлийн эхэнд илтгэлийн нэр /сэдэв/, зохиогчийн овог, нэр, эрдмийн зэрэг, цол, эрхэлж
- ✓ буй ажил, харилцах утасны дугаар, цахим хаягийг бичих
- ✓ Илтгэлийн нэр, хураангуйг монгол англи хэлээр бичсэн байх
- ✓ Илтгэлийн бүтэц: 5-8 түлхүүр үг, 250-400 үгэнд багтаан монгол, англи хэлээр бичсэн хураангуй, оршил, үндсэн агуулга, дүгнэлт, эшлэл авсан ном зүй, зураг хүснэгтийн жагсаалт хавсаргах, зургийг JPG, TIFF, хүснэгтийг Microsoft Excel программаар хавсаргах
- ✓ Илтгэлийг Microsoft Word программ ашиглан бичих
- ✓ Үсгийн фонт: Times New Roman, үсгийн хэмжээ: 11, мөр хоорондын зай: single, догол
- ✓ мөр: 5 тэмдэгт
- ✓ Илтгэлийн хэмжээ: A4 цаасны хэмжээтэй 5-10 хуудас

**Хурлын илтгэлийг бүрэн эх (Microsoft Word)-ээр нь 2022 оны 3 дугаар сарын 21-нийг дуустал хүлээн авна.**

### Зохион байгуулах ажлын хэсэгтэй холбоо барих хаяг:

Ажлын хэсгийн дарга:

МУИС, ШУС-ийн ХУС-ын Европ судлалын тэнхим Г.Бат-Учрал, Утас: 99016220

Ажлын хэсгийн нарийн бичиг:

МУИС, ШУС-ийн ХУС-ын Европ судлалын тэнхим Г.Эрдэнэнаран, Утас: 99880083

2022 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр